

**“ХИШИГ-УУЛ” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

2019 оны 04 дүгээр
сарын 26-ны өдөр

Дугаар _

Улаанбаатар
хот

*“Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх
асуудалд өгсөн саналын нэгдсэн дүнгийн талаар”*

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйл 67.3 дахь хэсгийг үндэслэн **ТОГТООХ**
НЬ:

Нэг. “Хишиг-Уул” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх
асуудалд хувьцаа эзэмшигчид доорх байдлаар санал өгсөн тухай хуралд оролцогчид болон
хурлын даргад мэдээлсүгэй.

№	Асуулт	Өгсөн санал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Хүчингүй	Хувь
1.	Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;	737 745	737 745	-	-	-	100 %
2.	Компанийн 2018 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг мөхөөрөмж батлах тухай;	737 745	737 745	-	-	-	100 %
3.	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах;	737 745	737 745	-	-		100 %
4.	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг улируулан сонгох;	737 745	737 745				100 %
5.	Компанийн 2019 оны үйл ажиллагааны талаар хэлэлцэх;	737 745	737 745				100 %
6.	Ашиглалтын хугацаа дууссан тоног төхөөрөмжүүдийг актлах тухай хэлэлцэх;	737 745	737 745				100 %

Хоёр. Саналын хуудас болон нэгтгэсэн дүнгийн тухай энэхүү тогтоолын нэг хувийг компанийн архивт хадгалуулахаар шилжүүлсүгэй.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА
ТООЛЛОГЫН КОМИССЫН ГИШҮҮН



“ХИШИГ-УУЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэг, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, “ХИШИГ-УУЛ” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4, 7.8.3 дахь хэсгийг тус тус удирдлага болгон “Хишиг-Уул” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах дараахь асуудлуудыг

ШИЙДВЭРЛЭХ НЬ:

НЭГДҮГЭЭР АСУУДАЛ. Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;

1. Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.11 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, “ХИШИГ-УУЛ” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.3 дахь хэсгийг тус тус удирдлага болгон компанийн 2018 оны үйл ажиллагаа тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж баталсугай.

ХОЁРДУГААР АСУУДАЛ. Компанийн 2018 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;

2. Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.11 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, “ХИШИГ-УУЛ” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.3 дахь хэсгийг тус тус удирдлага болгон компанийн 2018 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж баталсугай.

ГУРАВДУГААР АСУУДАЛ. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 үйл ажиллагааны тайланг сонсож, цаашид компанийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлэн ажиллахыг даалгасугай.

ДӨРӨВДҮГЭЭР АСУУДАЛ. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг улируулан сонгох

4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дараахь гишүүдийг улируулан сонгосугай.

Ердийн гишүүнээр

- 1) Ч.Мөнхбаяр

- 2) Ч.Ням-Оюун
- 3) Д.Энхтөр
- 4) Н.Цэцэнхаан
- 5) Я.Нэргүй
- 6) Э.Роза
- 7) Б.Энххорлоо

Хараат бус гишүүнээр

- 1) Д.Сэржамц
- 2) Д.Гонгор

ТАВДУГААР АСУУДАЛ. Компанийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэх;

5. Компани 2019 онд цаашид үйл ажиллагаагаа хэрхэн өргөжүүлэх боломжийн талаар судлан ажиллахыг ТУЗ-д даалгасугай.

ЗУРГААДУГААР АСУУДАЛ. Ашиглалтын хугацаа дууссан тоног төхөөрөмжүүдийг актлах тухай хэлэлцэх;

6. Ашиглалтын хугацаа дууссан тоног төхөөрөмжүүдийг акталж зохих бүртгэлийг хийсүгэй.

Бусад: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг хэрэгжүүлж зохих бүртгэлийг хуульд заасан хугацаанд тус тус зохих журмын дагуу бүртгүүлэхийг Өмгөөллийн “И Эл Си” ХХН-ийн хуульч С.Батчимэг, Т.Оюун-Эрдэнэ \РД:У397032985\ -д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Я.Нэргүй

Ц.Роза

Б.Энххорлоо

Г.Байгалмаа

М.Шигшээ



“Нийслэлийн Өмчийн Харилцааны
Газар”-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч

Ч.Мөнхбаяр

"ХИШИГ-УУЛ" ХК-ийн

Хувьцаа Эзэмшигчдийн хурлын тэмдэглэл

Хурал товлогдсон өдрөө буюу 2019 оны 04 дугаар сарын 26-ны өдрийн 15 цагт Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 3-р хороонд байрлах "Peace tower"-ын 9 давхар 905 тоот байранд 84,9%-ийн ирцтэйгээр хуралдлаа.

Хуралд оролцсон гишүүд:

1. Я.Нэргүй- 45,965 саналын эрх (5.29%)
2. Ц.Роза- 142,373 саналын эрх (16.39%)
3. Нийслэлийн өмчийн харилцааны газрыг төлөөлж: Ч.Мөнхбаяр- 295,206 (34%) саналын тус тус эрхтэйгээр оролцсон
4. Г.Байгалмаа – 37,130 саналын эрх (4.27%) /Итгэмжлэлээр/
5. Б.Энххорлоо- 217,063 саналын эрх (25%) /Итгэмжлэлээр/
6. М.Шигшээ – 8 саналын эрх (0,0009%)

Хурлын дарга: Ядам овогтой Нэргүй : Хувьцаа эзэмшигчдийн хурал нь Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай тогтоолын дагуу 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр товлосон газар товлосон цагтаа эхэлж байгааг энд дуулган Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-т Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно гэж заасны дагуу хүчин төгөлдөр болж байгаа тул хурлаар хэлэлцэх асуудлын талаар та бүхэндээ танилцуулж байна.

Хурлаар хэлэлцэх асуудлуудыг танилцууллаа:

Нэг. Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;

Хоёр. Компанийн 2018 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;

Гурав. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах;

Дөрөв. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг улируулан сонгох;

Тав. Компанийн 2019 оны үйл ажиллагааны талаар хэлэлцэх;

Зургаа. Ашиглалтын хугацаа дууссан тоног төхөөрөмжүүдийг актлах тухай хэлэлцэх;

Компанийн Танилцах баримт бичгийн жагсаалтанд байх баримт материалуудтай Хувьцаа эзэмшигч та бүхэн танилцсан байх. Хурлаар хэлэлцэх асуудлуудыг батлахтай холбоогоор ямар нэгэн санал хувьцаа эзэмшигч нарт байна уу? Байхгүй бол санал хураалтаа эхлүүлэе.

Хувьцаа эзэмшигч нар ямар нэгэн санал байхгүй гэснээр саналаа хураав.

Хурлын дарга: Ядам овогтой Нэргүй : Хишиг-Уул ХК-ын 2018 онд хийсэн ажлын тайлан болон танилцах боломжит материалуудын дагуу дэлгэрэнгүй танилцуулая. /Танилуулгыг хийв/

Хэлэлцэх асуудлын 1) Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах гэснийг дэмжиж буй Хувьцаа эзэмшигчид гараа өргөнө үү.

Санал хураалтанд 4 хувьцаа эзэмшигч оролцож, 4 хувьцаа эзэмшигч зөвшөөрсөн 100 хувийн саналаар батлагдав.

Хэлэлцэх асуудлын 2) Компанийн 2018 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах гэснийг дэмжиж буй Хувьцаа эзэмшигчид гараа өргөнө үү.

Санал хураалтанд 4 хувьцаа эзэмшигч оролцож, 4 хувьцаа эзэмшигч зөвшөөрсөн 100 хувийн саналаар батлагдав.

Хэлэлцэх асуудлын 3) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны үйл ажиллагааны тайланг батлах гэснийг дэмжиж буй Хувьцаа эзэмшигчид гараа өргөнө үү.

Санал хураалтанд 4 хувьцаа эзэмшигч оролцож, 4 хувьцаа эзэмшигч зөвшөөрсөн 100 хувийн саналаар батлагдав.

Хэлэлцэх асуудлын 4) Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг улируулан сонгох гэснийг дэмжиж буй Хувьцаа эзэмшигчид гараа өргөнө үү.

Санал хураалтанд 4 хувьцаа эзэмшигч оролцож, 4 хувьцаа эзэмшигч зөвшөөрсөн 100 хувийн саналаар батлагдав.

Хэлэлцэх асуудлын 5) Компанийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах гэснийг дэмжиж буй Хувьцаа эзэмшигчид гараа өргөнө үү.

Санал хураалтанд 4 хувьцаа эзэмшигч оролцож, 4 хувьцаа эзэмшигч зөвшөөрсөн 100 хувийн саналаар батлагдав.

Хурлын дарга: Ядам овогтой Нэргүй: Хэлэлцэх асуудлын 6) шиглалтын хугацаа дууссан тоног төхөөрөмжүүдийг актлах гэснээр танилцуулга хийв.

Санал хураалтанд 4 хувьцаа эзэмшигч оролцож, 4 хувьцаа эзэмшигч зөвшөөрсөн 100 хувийн саналаар батлагдав.

ШИЙДВЭР:

Нэг. Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж баталсугай.

Хоёр. Компанийн 2018 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж баталсугай.

Гурав. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны үйл ажиллагааны тайланг баталсугай.

Дөрөв. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг улируулан сонгосугай.

Тав. Компанийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсугай.

Зургаа. Ашиглалтын хугацаа дууссан тоног төхөөрөмжүүдийг акталсугай.

Дээрхи асуудлыг хэлэлцэж дуусаад хурлын дарга хурал хаасныг мэдэгдэв.

Хурал 2019 оны 04-р сарын 26-ны 16:30 цагт хаав.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн нарийн бичиг: _____ /Т.Оюун-Эрдэнэ/

Хурлын дарга: _____ Ядам овогтой Нэргүй /

